МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 04 өдөр Дугаар А/382 Мөрөн сум

Тусгай зөвшөөрлийг сунгах, захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.5, 19.17, 19.18, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 400 дугаар тушаалыг үндэслэн тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах байгууллагын жагсаалтыг хавсралтаар батлсугай.

2. Аймгийн Засаг даргын 2019 оны 288 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 4 дэх хэсэгт бичигдсэн "Мөнхтулгуур" эмнэлгийн байр гэснийг Мөрөн сумын 7-14-5 тоот гэж, аймгийн Засаг даргын 2017 оны А/270 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 4 дэх хэсэгт "Отгонтэнгэр" эмийн сан хаяг Мөрөн сумын 9-12-10 тоот гэснийг Мөрөн сумын 9-12-11а гэж, аймгийн Засаг даргын 2020 оны А/19 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтын 4 дэх хэсгийн "Онжинжалба" эмнэлгийн ажлын байр "Улаан загалмай" гэснийг Мөрөн сумын 6-1-8 тоот гэж, аймгийн Засаг даргын 2019 оны А/288 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсэгт бичигдсэн "Хүмүүн" эмнэлгийн "Дотрын клиник" гэснийг "Дотор уламжлал, сэргээн засах эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ" гэж тус тус өөрчилсүгэй.

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), Эрүүл мэндийн газар (М.Үүрийнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Эрүүл мэндийн багц хууль болон эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангуудад холбогдох стандарт, эмнэлзүйн удирдамжуудыг мөрдөж ажиллахыг эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны
11 дүгээр сарын 07-ны өдрийн А/382
дүгээр захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ БАЙГУУЛЛАГУУДЫН НЭРС

№	Тусгай зөвшөөрөл хүсэгчийн мэдээлэл	Эрхлэх үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Ажлын байрны хаяг	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	"Циркон -Энэр" ХХК	"Циркон" эмнэлэг Эх барих Эмэгтэйчүүдийн эмнэлэг	Т.Гэрэлчулуун	Мөрөн сум 8-р баг Циркон эмнэлгийн байр	2022-11-11 2027-11-11
2	"Төгс монгол Ану" ХХК	"Төгсдент" шүдний эмнэлэг	Ч.Лонжид	Мөрөн сум 8-р баг Циркон эмнэлгийн байр	2022-07-31 2027-07-31
3	"Тахилт алтан бумба" ХХК	"Тахилт алтан бумба" эмийн сан	М.Балжинням	Мөрөн сум 3-р баг Нэмэн төвийн байранд	2022-10-11 2027-10-11
4	"Еврофарм"ХХК	Эм эмнэлгийн хэрэгслийн бөөний худалдаа	Ж.Оюунсүрэн	Мөрөн сум 4-р баг 4-6-23	2022-11-24 2027-11-24
5	"Мөнх-Ундрам"фарм ХХК	2-р зэрэглэлийн эмийн сан	Ж.Оюунтуяа	Галт сум 5-р баг	2022-10-30 2027-10-30
6	"Нано-Од"ХХК	"Нано дент" шүд эрүү нүүрний эмнэлэг	Н.Жавзанпагма	Мөрөн сум 7-р баг Масс төвийн байранд	2022-10-11 2027-10-11
7	"Түгээмэл сайхан" ХХК	Нүүр амны шүдний оношлогоо эмчилгээ,согог заслын тусламж үйлчилгээ	Г.Нямсайхан	Мөрөн сум 8-р баг 28-р байрны 05 тоот	2022-08-23 2027-08-23
8	"Төгс энх мэлмий"ХХК	"Энхмэлмий" нүдний эмнэлэг	Г.Хүрлээ	Мөрөн сум 8-р баг циркон эмнэлгийн байранд	2022-11-24 2027-11-24
9	"Хүмүүн" ХХК	"Хүмүүн" эмнэлэг	Ө.Отгонцэрэн	Мөрөн сум 5-р баг "Хүмүүн" эмнэлгийн байр	2022-11-11 2025-11-11
10	"Лили фарм"ХХК	2-р зэрэглэлийн эмийн сан	Г.Мөнхцэцэг	Мөрөн сум 14-р баг 6-1	2022-11-11 2027-11-11

_____oOo_____